


**Нэгдсэн санхүүгийн тайлан ба  
Хараат бус аудиторын тайлан**  
**“Ард санхүүгийн нэгдэл” ХК**

2020 оны 12 дугаар сарын 31



# Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	1
Нэгдсэн санхүүгийн байдлын тайлан	4
Нэгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
Нэгдсэн ёмчийн өөрчлөлтийн тайлан	7
Нэгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
Нэгдсэн мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)	9
Нэгдсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд	10

# Группийн тухай товч мэдээлэл

ГРУППИЙН НЭР:	Монгол	Ард санхүүгийн нэгдэл ХК
ТУЗ-ИЙН ГИШҮҮД:	Дарга Гишүүд Хараат бус гишүүн	П.Батбаяр Ч.Ганхуяг Бруно Рашиле А.Сүхдорж Х.Батхишиг О.Одбаяр М.Сэргээн Ч.Мөнхбат Михаил Зелдович Арнауд Вентура
УДИРДЛАГЫН БАГ:	Гүйцэтгэх захирал Маркетинг эрхэлсэн захирал Санхүү эрхэлсэн захирал Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Дижитал технологийн захирал Дотоод аудитор Хууль нийцүүлэлт эрхэлсэн менежер Ерөнхий нягтлан бодогч	Ч.Ганхуяг Б.Ариунаа Б.Золбоо Э.Амарбаясгалан Ж.Алтангүний Г.Тэнүүн М.Мөнх-Эрдэнэ С.Анар-Эрдэнэ Г.Сэлэнгэ
ГРУППИЙН ХАЯГ:	Групп нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ард санхүүгийн нэгдлийн байр 2 дугаар давхар	
РЕГИСТРИЙН ДУГААР:	2001861	
ҮЙЛ АЖИЛЛАГАА:	Хөрөнгө оруулалт, Бизнесийн зөвлөгөө	
АЖИЛЛАГСАДЫН ТОО:	12	
АУДИТОР:	"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага	

# Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь нэгдсэн санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Группийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохицтой толилуулах үүрэгтэй.

Нэгдсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:


- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Нэгдсэн санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаяр, гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг болон ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгэ бид энэхүү тайлангийн 4-9 дүгээр хуудсанд үзүүлсэн группийн нэгдсэн санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх группийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

  
П.Батбаяр  
ТУЗ-ийн дарга  
  
Ч.Ганхуяг  
Гүйцэтгэх захирал

Огноо: 2021.08.09

Огноо: 2021.08.09

  
Г.Сэлэнгэ  
Ерөнхий нягтлан бодогч

Огноо: 2021.08.09



**Grant Thornton**

### **"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК**

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,  
ЮНЕСКО гудамж - 31,  
Сүхбаатар дүүрэг,  
1 хороо Улаанбаатар  
14230, Монгол улс  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,  
UNESCO street - 31,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230,  
Mongolia  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

# **Хараат бус аудиторын дүгнэлт**

**"Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:**

#### **Дүгнэлт**

Бид "Ард санхүүгийн нэгдэл" ХК (цаашид "Групп" гэх) болон түүний нийтлэх хяналт бүхий компаниуд (хамтад нь "групп" гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- нэгдсэн санхүүгийн байдлын тайлан,
- уг өдрөөр дуусгавар болсон жилийн нэгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан,
- нэгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан,
- нэгдсэн мөнгөн гүйлгээний тайлан болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, "Ард санхүүгийн нэгдэл" ХК болон түүний салбар компаниуд (хамтад нь "групп" гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх нэгдсэн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлангын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хулээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хулээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

#### **Хараат бус байдал**

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Группээс хараат бус бөгөөд здгээр ёс зүйн шаардлагуудад нийцуулэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

#### **Аудитын аргачлалын хураангуй**

Аудитын гол асуудлууд

- СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр"-т заасан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэх өмчид оруулсан хөрөнгө оруулалтын шаардлагуудыг хэрэгжүүлснээр тайлант он болон өмнөх оны ашиг, алдагдалд томоохон өөрчлөлт орсон.
- Виртуал хөрөнгийн бүртгэлд НББОУС 38 "Биет бус хөрөнгө" стандартын дахин үнэлгээний хандлагыг ашиглан бүртгэсэн.



- Тайлант хугацаанд групп нь СТОУС 16 "Түрээсийн хөрөнгө"-ийн хэрэгжүүлсэн.
- Групп нь хөрөнгө оруулалтын ААН-ийн шалгуур, тодорхой шинжүүдийг хангаж байгаа боловч санхүүгийн тайлангаа хөрөнгө оруулалтын бус ААН-ийн үүднээс бэлтгэж, олон нийтэд танилцуулдаг байна.
- НББ-ийн тухай хуульд заасны дагуу СТОУС-ыг дагаж мөрдөх үүрэгтэй боловч СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр"-т заасан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

**Аудитын цар хүрээ**

- Групп нь тодруулга 5-д заасан компаниудыг эзэмшдэг бөгөөд энэхүү тайлан нь "Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн нэгдсэн санхүүгийн тайлан болно.

**Материаллаг байдал**

- Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 235,956 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт орлогын 1%-иар тооцсон.

**Онцлох асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн суурь болон энэхүү тайланг ашиглах болон тараах талаарх хязгаарлалт-Бид та бүгдийг энэхүү нэгдсэн тайлангийн тодруулга 1-д дурдсан мэдээлэлд анхаарлаа хандуулахыг хүсч байна. Энэхүү нэгдсэн тайланг Ард санхүүгийн нэгдлийн удирдлагын мэдээллийн зорилгоор бэлтгэсэн бөгөөд группийн хяналт бүхий бүх компани хамрагдаагүй болно.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нелөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгдсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Эрсдэл	Эрсдэлд авсан хариу арга хэмжээ
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэхээр ангилсан өмчид оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн неөцийг тайлант онд болон өмнөх онд ашиг, алдагдалд шилжүүлэн бүртгэсэн. Мөн тайлант онд борлуулсан хөрөнгө оруулалтад ногдох бодит үнэ цэнийн неөцийг ашиг, алдагдалд шилжүүлэн бүртгэсэн.	Аудитын горим: СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр" стандартын шаардлагад худалдан арилжих зорилгоор эзэмшээгүй, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн дараа үеийн өөрчлөлтийг аж ахуйн нэгж нь анх хүлээн зөвшөөрхдөө бусад дэлгэрэнгүй орлогод толилуулахаар удирдлага шийдсэн бол бодит үнэ цэнийн неөцийг дараагийн тайлант үед ашиг, алдагдалд шилжүүлэхгүй байхаар заасан байдаг бөгөөд тус шаардлагын дагуу өмнөх онд болон тайлант онд зохих запруулгыг хийсэн.
Виртуал хөрөнгийг хэрхэн бүртгэх тухай хууль тогтоомж болон СТОУС-н шаардлага хараахан гараагүй байгаа боловч хамгийн тохиромжтой хандлагыг ашиглан санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсэн.	Аудитын горим: СТОУС-ын Тайлбарын хорооноос гаргасан криптовалют буюу виртуал хөрөнгийг эзэмшиж буй үед НББ-д хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэх зөвлөмжийг гаргасан. Уг зөвлөмжийн дагуу НББОУС 38 "Биет бус хөрөнгө"-ийн Дахин үнэлгээний загвар илүү тохирно гэж группийн удирдлага үзсэн учир виртуал хөрөнгөтэй холбоотой запруулгыг хийсэн.

Эрсдэл	Эрсдэлд авсан хариу арга хэмжээ
СТОУС 16 "Түрээс" стандартын дагуу түрээслэсэн хөрөнгүүдийн хувьд ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг анх удаа хүлээн зөвшөөрсэн.	Удирдлагын хариу арга хэмжээ: Групп нь СТОУС 16 "Түрээс" стандартыг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж, санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрсэн.  Аудитын горим: Группийн удирдлагын хүлээн зөвшөөрсэн ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө, түрээсийн өр төлбөрийг давтан тооцоолж, зохих запруулгыг хийсэн.
Групп нь хөрөнгө оруулалтын ААН-ийн шалгуур, тодорхой шинжүүдийг хангаж байгаа боловч санхүүгийн тайлангаа хөрөнгө оруулалтын бус ААН-ийн үүднээс бэлтгэж, олон нийтэд тусдаа санхүүгийн тайлангаа танилцуулдаг.	Аудитын горим: "Ард санхүүгийн нэгдэл" ХК нь дүрмэндээ хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулна гэж заасан ба группийн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын ААН-ийн ихэнх шинжүүдийг хангаж байна. Группийн удирдлага нь цаашид СТОУС 10 "Нэгтгэсэн санхүүгийн тайлан"-гийн 31-д заасны дагуу Хөрөнгө оруулалтын ААН-ийн статусыг баталгаажуулж, цаашид нийтлэх хяналт бүхий компаниуд оруулсан хөрөнгө оруулалтаа СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр"-т заасны дагуу ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих, нэгтгэлээс чөлөөлөгдхөн бодлогыг авч хэрэгжүүлэх тухай аудиторын зөвлөмжийг хүлээн зөвшөөрсэн.
СТОУС 36 "Хөрөнгийн үнэ цэнийн бууралт" стандартын дагуу бизнесийн нэгдлээр бий болсон гүүдвлийн үнэ цэнийн бууралтыг тооцож бүртгээгүй.	Аудитын горим: СТОУС 36 "Хөрөнгийн үнэ цэнийн бууралт" стандартын дагуу гүүдлийн үнэ цэнийн бууралтыг жил бүр тооцон, шалгаж байх зөвлөмжийг гаргасан.

### Бусад асуудал

Группийн 2019 оны нэгдсэн санхүүгийн тайландаа "Далайван Аудит" ХХК аудит хийж, зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл Группийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайландаа багтсан мэдээллээс бүрдэх ба харин нэгдсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлангаа багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Нэгдсэн санхүүгийн тайландаа өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Нэгдсэн санхүүгийн тайландаа бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед үншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь нэгдсэн санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Нэгдсэн Санхүүгийн тайландаа хүлээх үүрэг хариуцлага

Группийн удирдлага эдгээр нэгдсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлagnalын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь нэгдсэн санхүүгийн тайлангаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь нэгдсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Группийн үйл ажиллагааг зогсоо юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах группийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлagnalын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

#### **Санхүүгийн тайлagnalын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгдсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ нэгдсэн санхүүгийн тайландаа үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

**Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд аяч үзсэн талаарх тайлбар**

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас нэгдсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиromжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиландаа хийвалдаан, бичиг баримт хурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхуйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгдсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад нэгдсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж нэгдсэн санхүүгийн тайландаа үнэн зөв толилуулын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Нэгдсэн санхүүгийн тайландаа дүгнэлт өгөхийн тулд групп доторх аж ахуй нэгжүүд, бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай аудитын нотлох баримтыг цуглуулах. Бид группийн аудитын чиглэл, хяналт, гүйцэтгэлийг хариуцна. Бид аудитын дүгнэлтийг бүрэн хариуцах болно.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.


Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн Нэгдсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү серэг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

**Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.

  
ГРАНТ ТОРНТОН  
AUDIT LLC  
  
Б.ОСОРГАРАДЫН ХХК  
УДИРДАХ ПАРТНЕР  
УЛААНБААТАР ХОТ  
1118276081 ▷ 2577542  
2021 оны 08 дугаар сарын 09  
Улаанбаатар хот

  
Н.ЭРДЭНЭЦОГ  
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

# Нэгдсэн санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8	16,052,217 ✓	11,209,449 ✓
Дансны болон бусад авлага	9	8,189,031 ✓	3,091,636 ✓
Харилцагчдад олгосон зээл	10	20,634,725 ✓	19,269,712 ✓
Хараат болон бусад компанийд оруулсан хөрөнгө оруулалт	11	29,915,559	20,495,395
Бараа материал	12	47,818 ✓	49,948 ✓
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	13	6,251,982 ✓	2,906,136 ✓
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	14	7,007,626 ✓	7,227,554 ✓
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>88,098,958</b>	<b>64,249,830</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	15	4,334,632 ✓	2,232,317 ✓
Биет бус хөрөнгө	16	18,281,009 ✓	4,946,385 ✓
Гүдвилл	17	6,187,485 ✓	6,187,485 ✓
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>28,803,126</b>	<b>13,366,187</b>
<b>Нийт хөрөнгө</b>		<b>116,902,084 ✓</b>	<b>77,616,017 ✓</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
<b>Өр төлбөр</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	18	27,041,687	21,287,345
Урьдчилж орсон орлого	19	8,065,414 ✓	5,171,110
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	20	22,977,675 ✓	13,044,145 ✓
Санхүүгийн түрээсийн өглөг	21	349,718 ✓	40,096 ✓
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>58,434,494</b>	<b>39,542,696</b>

# Нэгдсэн санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Неөц /өр төлбөр/	22	3,196,597	3,080,571
Урт хугацаат зээл	20	4,299,338	8,261,238
Хойшлогдсон татварын өр	23	1,068,156	224,848
Санхүүгийн түрээсийн өвлөг	21	379,093	262,390
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>8,943,184</b>	<b>11,829,047</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>67,377,678</b>	<b>51,371,743</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувийн өмч	24.1	28,590,335	28,590,335
Халаасны хувьцаа		(7,510,035)	(11,389,968)
Нэмж төлөгдсөн капитал	25	(4,574,947)	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	26	11,240,171	98,382
Эздийн өмчийн бусад хэсэг	27	7,269,121	13,799
Тусгай зорилготой неөц		-	25,721
Цөөнхийн хувь оролцоо	28	7,730,262	6,830,705
Хуримтлагдсан ашиг	29	6,779,499	2,075,300
Толгой компанийн зээмшигчдэд ногдох		6,779,499	2,075,300
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>49,524,406</b>	<b>26,244,274</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>		<b>116,902,084</b>	<b>77,616,017</b>

Уг нэгдсэн санхүүгийн тайланг 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдөр батлав:

Ч.Ганхуяг  
Гүйцэтгэх захирал



Г.Сэлэнгэ  
Ерөнхий наяглан бодогч

Энэхүү нэгдсэн санхүүгийн байдлын тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 6-с 47 дугаар хуудсан дах нэгдсэн санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлилэв.

# Нэгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
Орлого	30	14,299,235	10,209,760
Өртөг	31	(4,061,708)	(6,390,314)
<b>Нийт ашиг</b>		<b>10,237,527</b>	<b>3,819,446</b>
Түрээсийн орлого	32	543,355	121,754
Санхүүгийн орлого	33	6,761,304	9,645,316
Бусад орлого	34	1,928,996	2,670,850
Борлуулалт, маркетингийн зардал	35	(3,929,213)	(5,173,436)
Ерөнхий ба удирдлагын зардал	36	(8,429,523)	(8,783,093)
Санхүүгийн зардал	33	(5,936,627)	(3,375,357)
Бусад зардал	37	(2,531,852)	(1,244,893)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	38	(478,244)	(39,412)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(1,222,710)	49,904
Хөрөнгө оруулалтын борлуулснаас үүссэн олз (гарз)		62,670	3,193,489
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>(2,994,317)</b>	<b>884,568</b>
Орлогын татварын зардал	39	(487,145)	(623,247)
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>(3,481,462)</b>	<b>261,321</b>
Хяналтын эрхгүй хувь оролцооны хүүгийн зардал	40	(997,902)	(1,159,161)
Групп компанийн алдагдал		(4,479,364)	(897,840)
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>			
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц		8,381,395	97,618
<b>Бусад дэлгэрэнгүй орлогын дүн</b>		<b>3,902,031</b>	<b>(800,222)</b>

Энэхүү нэгдсэн орлогын дэлгэрэнгүй тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 6-с 47 дугаар хуудсан дах нэгдсэн санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

## Нэгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Минган төгрөгөөр	Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох									Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт өмч	
	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлгөсөн капитал	Хөрөнгө оруулалтын үнэлгээний неец	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай зориулалттай неец	Эздин өмчин бусад хэсэг	Хуриитлагдсан ашиг	Нийт дун			
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,879,653	(441,474)	2,689,664	-	627	21,110	13,799	27,120,260	31,283,639	4,112,841	35,396,480	
Тайлант усийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-	(897,840)	(897,840)	1,159,161	261,321	
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Өмчид гарсан өөрчлөлт	26,710,682	(10,948,494)	(2,689,664)	-	-	4,611	-	56,208	13,133,343	1,558,703	14,692,046	
Зарласан ногдл ашиг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дун	-	-	-	97,618	137	-	-	-	-	97,755	-	97,755
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	28,590,335	(11,389,968)	-	97,618	764	25,721	13,799	26,278,628	43,616,897	6,830,705	50,447,602	
Нияглан бодох буртгэлийн болдогын өөрчлөлтийн нөлөө, алдааны зарцуулга	-	-	-	-	-	-	-	(24,203,328)	(24,203,328)	-	(24,203,328)	
Зарлуулсан үлдэгдэл	28,590,335	(11,389,968)	-	97,618	764	25,721	13,799	2,075,300	19,413,569	6,830,705	26,244,274	
Тайлант усийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-	(4,479,364)	(4,479,364)	997,902	(3,481,462)	
Өмчид гарсан өөрчлөлт	-	3,879,933	(4,574,947)	-	-	(25,721)	7,255,322	9,183,563	15,718,150	(98,345)	15,619,805	
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дун	-	-	-	10,347,761	794,028	-	-	-	11,141,789	-	11,141,789	
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	28,590,335	(7,510,035)	(4,574,947)	10,445,379	794,792	-	7,269,121	6,779,499	41,794,144	7,730,262	49,524,406	

Энэхүү нэгдсэн өмчийн өөрчлөлтийн тайланг тодруулгыудын хамт унших багаад 6-с 47 дугаар хуудсан дах нэгдсэн санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Нэгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2020	2019
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>29,200,243</b>	<b>24,377,247</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	28,178,763	18,631,016
Даатгалын нэхвереес хүлээн авсан мөнгө	100,828	1,332
Бусад мөнгөн орлого	920,652	5,744,899
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(22,810,653)</b>	<b>(26,527,597)</b>
Ажиллагчдад төлсөн	(3,050,387)	(2,906,731)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(416,349)	(755,690)
Бараа материал худалдан авахад төлсөн	(172,369)	(245,104)
Ашиглалтын зардалд төлсөн	(661,958)	(460,787)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(155,298)	(106,888)
Хүүний төлбөрт төлсөн	(2,490,227)	(1,703,707)
Татварын байгууллагад төлсөн	(1,403,550)	(1,066,522)
Даатгалын төлбөрт төлсөн	(37,085)	(74,448)
Бусад мөнгөн зарлага	(14,423,430)	(19,207,720)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>6,389,590</b>	<b>(2,150,350)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>53,938,109</b>	<b>44,465,478</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	153,420	345,752
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	5,268,059	5,923,573
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлелт	46,333,056	32,984,804
Хүлээн авсан хүүний орлого	1,327,301	4,705,150
Хүлээн авсан ногдол ашиг	143,468	506,199
Бусад мөнгөн орлого	712,805	-
	153,420	345,752

# Нэгдсэн мөнгөн гүйлгээний тайлан (ургэлжлэл)

Мянган төгрөгөөр	2020	2019
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(61,452,337)</b>	<b>(51,366,995)</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(752,098)	(795,720)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(32,100)	(32,037)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(8,862,029)	(10,241,285)
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(170,000)	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(51,636,110)	(40,297,953)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(7,514,228)</b>	<b>(6,901,517)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>14,357,079</b>	<b>18,634,463</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,976,613	3,369,143
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,930,660	14,945,655
Бусад мөнгөн орлого	449,806	319,665
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(8,395,449)</b>	<b>(8,986,129)</b>
Зээл, өрийн үнэт цаасны телбөрт төлсөн мөнгө	(2,147,545)	(8,418,282)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	(224,543)	-
Хувьцаа буцаан худалдах авахад төлсөн	(2,987,546)	-
Төлсөн ногдол ашиг	(1,533,276)	(567,847)
Бусад мөнгөн зарлага	(1,502,539)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,961,630</b>	<b>9,648,334</b>
<b>Валютын ханшийн зерүү</b>	<b>5,776</b>	<b>-</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>4,842,768</b>	<b>596,467</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>11,209,449</b>	<b>10,612,982</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>16,052,217</b>	<b>11,209,449</b>

Энэхүү нэгдсэн мөнгөн гүйлгээний тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 6-с 47 дугаар хуудсан дах  
нэгдсэн санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бурдүүлнэ.